

МББСБХолбооны 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн
Бүх гишүүдийн хурлын БГХ/2025-04 тоот
тогтоолоор шинэчлэн батлав.

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Оноосон нэр: Холбооны албан ёсны нэр Монгол хэл дээр, “МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО”, товчилбол “МББСБХ”, Англи хэл дээр “MONGOLIAN NON-BANKING FINANCIAL INSTITUTIONS ASSOCIATION”, товчилбол “MNBFA” болно.
- 1.2 Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо (цаашид “Холбоо” гэх) нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлийн үндсэн дээр банк, санхүүгийн тодорхой үйл ажиллагаа эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудыг сайн дураар нэгтгэсэн, төрөөс хараат бус, бие даасан, ашгийн төлөө бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.
- 1.3 Холбоо нь Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.4 Холбоо нь Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 1.5 Холбооны албан ёсны хаяг: Холбооны албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Жуулчны гудамж, Макс цамхаг, 4-р давхар, 403 тоот Вэб сайт: www.bbsb.mn
- 1.6 Холбооны дүрмийг анхлан баталсан 2002 оны 11-р сарын 08-ны өдөр нь Холбоог үүсгэн байгуулсан өдөр байх бөгөөд зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.
- 1.7 Холбоо нь өөрийн нэр бүхий тамга, тэмдэг, билэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ХОЁР. ХОЛБООНЫ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1 Холбооны үндсэн зорилго нь:
 - 2.1.1 Холбооны гишүүдийн хууль ёсны эрх, нийтлэг ашиг сонирхолыг төрийн захиргааны болон хууль хяналтын байгууллагын өмнө төлөөлөн хамгаалах, энэ чиглэлээр хамтран ажиллах;
 - 2.1.2 Өөрийн гишүүдэд үйлчлэх тухайлбал, олон улсын болон өөрийн орны банк, санхүүгийн салбарын холбогдолтой төрөл бүрийн мэдээллээр хангах, мэдээллийн зохих санг буй болгох, гишүүн байгууллагын үйл ажиллагаа, нийгэмд оруулж буй хувь нэмрийг

сурталчлах, олон нийтэд таниулах, тэдгээрийн ажилнуудыг сургалт, семинар, давтан сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны стандартуудыг тогтоож хөгжүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулах;

2.1.3 Олон улсын болон гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, холбоодтой харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллахад оршино.

2.2 Холбоо нь өөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг үндсэн чиглэлээ болгоно.

2.2.1 Банк бус санхүүгийн байгууллагын салбарыг хөгжүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

2.2.2 Банк бус санхүүгийн байгууллагын салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төрийн эрх бүхий байгууллагаас холбогдох эрх зүйн акт батлан гаргах явцад салбарын эрх ашгийг төлөөлж оролцох, санал, дүгнэлт, мэдэгдэл гаргах, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.2.3 Холбооны үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороо, Банк, санхүүгийн бусад байгууллага, Холбоо, ижил төрлийн гадаад, дотоодын болон олон улсын байгууллага, холбоодтой уялдуулан зохицуулах, харилцан ойлголцох, итгэлцэл, түншлэлийг бий болгох, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.2.4 Банк бус санхүүгийн байгууллагын салбарын үйл ажиллагаанд болон энэхүү салбарын ажилтанд хамаарах төрөл бүрийн стандартуудыг тогтоож нэвтрүүлэх, хэвшүүлэх, цаашид боловсронгуй болгох;

2.2.5 Банк болон банк бус санхүүгийн байгууллагын тогтолцоо, удирдлага, үйл ажиллагаа, санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин, чиг хандлага, санхүүгийн эрсдэл, бусад орны туршлага, үйлчилгээний шинэ хэлбэр, загварын талаар судалгаа явуулах, үнэлэлт дүгнэлт өгөх, Холбооны болон гишүүн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, ашиглах;

2.2.6 Холбооны гишүүдийг дэмжихэд болон холбооны үйл ажиллагаа, үр нөлөө, санхүүг бэхжүүлэхэд чиглэсэн бусад арга хэмжээг зохион байгуулах;

ГУРАВ. ХОЛБООНЫ БҮТЭЦ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,

ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

3.1 Холбоо нь Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, ажлын алба гэсэн үндсэн бүтэцтэй байна.

3.2 **Холбооны Бүх гишүүдийн хурал:**

3.2.1 Холбооны эрх барих дээд байгууллага нь Холбооны Бүх гишүүдийн хурал байх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ;

а. Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

б. Холбооны бүтэц зохион байгуулалтыг батлах;



- в. Холбооны удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх;
- г. Холбооны үйл ажиллагаа болон Удирдах Зөвлөл, Хяналтын Зөвлөлийн ажлын тайланг сонсох, хэлэлцэх, дүгнэлт өгөх;
- д. Холбооны жилийн төсвийг батлах;
- е. Гишүүний татварын хэмжээг тогтоох;
- ё. Холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;
- ж. Хуульд заасан бусад эрх;
- з. Холбооны өмчлөлийн үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах;

3.2.2 Бүх гишүүдийн хурлыг Холбооны Удирдах зөвлөл жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг гишүүдийн 2/3-ын саналын дагуу зарлан хуралдуулж болно.

3.2.3 Бүх гишүүдийн хурлыг Ерөнхийлөгч даргалж хуралдуулах бөгөөд гишүүн бүр хуралд саналын нэг эрхтэй оролцоно.

3.2.4 Холбооны Бүх гишүүдийн ердийн олонхи /50+1 хувь/ оролцсоноор хурал хүчинтэйд тооцогдох бөгөөд хуралд оролцсон нийт гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэр (тогтоол) гаргах ба хурлын явцад тэмдэглэл хөтөлнө.

3.2.5 Хурлын зарыг хуанлийн 14 хоногийн өмнө урьдчилан гишүүдэд хүргэх бөгөөд хурлын ирц бүрдээгүй тохиолдолд дахин зарлаж хуралдуулах ба гишүүдийн 30-аас доошгүй хувь оролцсон бол дахин зарласан хурлыг хүчин төгөлдөрт тооцно.

3.2.6 Бүх гишүүдийн хурлыг Холбооны удирдах зөвлөлийн шийдвэрээр цахим хэлбэрээр хуралдуулж болно.

3.3 Холбооны удирдах зөвлөл:

3.3.1 Бүх гишүүдийн хурлаас бусад үед Удирдах зөвлөл нь Холбооны эрх барих дээд байгууллагын үүргийг гүйцэтгэнэ.

3.3.2 Удирдах Зөвлөлийн гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна;

а. Холбооны гишүүн ББСБ-г төлөөлөх бүрэн эрх бүхий удирдах дээд албан тушаалтан байх

б. Уг албан тушаалтан нь банк, санхүүгийн салбарт 5-с доошгүй жил Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаал, газар, хэлтэс, салбар нэгжийн удирдлагын эрх бүхий албан тушаал хашиж байсан, ямарваа ял шийтгэл хүлээж байгаагүй байх

в. Мэргэжлийн ёс зүйтэй, сонирхлын зөрчилгүй байх

г. Банк бус санхүүгийн салбарын хууль, эрх зүйн мэдлэгтэй байх

д. Салбарын тогтвортой хөгжилд онцгой хувь нэмэр оруулах, гишүүдийн нийтлэг эрх ашгийн төлөө идэвх зүтгэлтэй, хариуцлагатай ажиллахаа илэрхийлсэн байх



е. Төлөөлж буй ББСБ нь сүүлийн 2 жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийн хүрээнд ямар нэгэн зөрчилгүй байж, 2-оос доошгүй жилийн хугацаанд холбооны гишүүн байсан

ё. Удирдах зөвлөлийн гишүүнээр нэр дэвших болон Удирдах зөвлөлийн гишүүн байх хугацаандаа улс төрийн намын аль нэг албан тушаалтан, сонгуульд нэр дэвшигч байх, аль нэг намыг төлөөлөхгүй байх

ж. Санхүүгийн зохицуулах хорооны “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын шаардлагыг хангасан байх

3.3.3 Удирдах зөвлөл нь 13 гишүүнтэй байх бөгөөд хамгийн багадаа 4 гишүүн нь улиран сонгогдоно.

3.3.4 Удирдах зөвлөлийн гишүүд нь 2 жилийн хугацаатай сонгогдож, 2 удаа дараалан улиран сонгогдож болох бөгөөд дараагийн гишүүн нь сонгогдсоноор бүрэн эрх нь дуусгавар болно.

3.3.5 Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а. Холбооны үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлах;

б. Холбооны ерөнхийлөгчийг Удирдах зөвлөл ердийн олонхийн саналаар 3 жилийн хугацаатай сонгож, 1 удаа улируулан сонгож болно;

в. Холбооны УЗ-ын гишүүнийг эргүүлэн татах;

г. Холбооны УЗ-ын гишүүнийг дараагийн сонгууль хүртлэх хугацаанд нөхөн томилох;

д. Саналын эрхгүй УЗ-ын гишүүнийг дараагийн сонгууль хүртлэх хугацаанд томилох, чөлөөлөх эрхтэй. Саналын эрхгүй УЗ-ын гишүүн нь хоёроос дээшгүй байж болно.

е. Холбооны Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх;

ё. Холбооны өмч хөрөнгийг захиран зарцуулах талаарх Гүйцэтгэх захирлын эрх, хэмжээг тогтоох, түүнтэй байгуулах гэрээг хэлэлцэн батлах;

ж. Холбооны харъяа байгууллагыг байгуулах, Гүйцэтгэх захирлын удирдлага дор ажиллах ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, түүний төсвийг батлах;

з. Удирдах зөвлөлийн дэргэд байнгын болон түр хороо ажлуулж болно.

и. Холбооны гишүүдийг шинээр элсүүлэх, чөлөөлөх, гишүүдийн татвар төлөх журмыг тогтоох;


й. Гишүүний ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих

к. Хуульд заасан бусад эрх;

л. Дүрмийн 3.3.2.ё заалтыг зөрчсөн гишүүнийг Ерөнхийлөгчийн саналаар гишүүнээс хасах эрхтэй;

м. Ерөнхийлөгчийн саналаар дэд ерөнхийлөгчийг эргүүлэн татна;

3.3.6 Удирдах зөвлөлийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар, эсвэл Ерөнхийлөгчийн саналаар ээлжит бус



хурлыг хуралдуулж болно. Зөвлөлийн гишүүдийн ердийн олонхи хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөрт тооцогдоно.

- 3.3.7 Шаардлагатай болон зайлшгүй тохиолдолд хурлыг цахим хэлбэрээр хийж болно.
- 3.3.8 Удирдах зөвлөлийн гишүүд аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэгш эрхтэй оролцоно. Зөвлөлийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар, хуралд оролцогч гишүүдийн олонхийн саналаар шийдвэрийг гаргана.
- 3.3.9 Удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд даргалагч гарын үсэг зурж, Холбооны тамга дарснаар баталгаажина. Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, зарчмын өөр санал гаргасан гишүүний тайлбар зэргийг тусгана.
- 3.3.10 Удирдах зөвлөлийн хурлыг Ерөнхийлөгч удирдана. Түүний эзгүйд болон түүний чөлөөт цагт хурлыг Удирдах Зөвлөлийн гишүүдийн ердийн олонхийн санал авсан гишүүн удирдан явуулна.
- 3.3.11 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 2-оос доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан ББСБ нь МББСБХ-ны Удирдах зөвлөлд сонгогдох эрхтэй.

3.4 Холбооны Ерөнхийлөгч:

- 3.4.1 Ерөнхийлөгч нь дараахь шалгуурыг хангасан Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн байна. Үүнд:
- а. Банк, санхүүгийн салбарт 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан туршлагатай, үндсэн бизнес нь ББСБ байдаг;
 - б. Хугацаа хэтэрсэн өр зээлгүй, ямар нэгэн ял шийтгэл эдэлж байгаагүй;
 - в. Зохион байгуулах, манлайлах чадвартай, ажлын идэвхи санаачлага сайтай байх;
 - г. Холбооны Удирдах зөвлөлд 2-оос доошгүй жил ажилласан байх, ажилласан хугацааны ирц 80 хувиас багагүй байх
 - д. Ашиг сонирхлын зөрчилгүй, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалахаа илэрхийлсэн байх
 - е. Холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд тогтвортой ажиллахаа илэрхийлсэн байх
 - ё. Төлөөлж буй ББСБ-ын 10 хувиас доошгүй хувьцаа эзэмшигч байх
- 3.4.2 Холбооны Ерөнхийлөгч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- а. Холбооны Удирдах зөвлөлийн хурлыг даргалах;
 - б. Холбоог гадаад, дотоодод төлөөлөх;



- в. Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн холбооны гүйцэтгэх захиралтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажилуулах, дүгнэх;
- г. Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах, бэлтгэлийг хангуулах;
- д. Хуульд заасан бусад эрх;
- е. Холбооны дэд ерөнхийлөгчийг эргүүлэн татах саналыг Удирдах зөвлөлд гаргах;

3.5. Холбооны дэд ерөнхийлөгч:

3.5.1. Холбоо нь дэд ерөнхийлөгчтэй байж болох бөгөөд Холбооны ерөнхийлөгч нэр дэвшүүлж Удирдах зөвлөлийн шийдвэрээр томилно.

3.5.2. Холбооны дэд ерөнхийлөгч нь дараах шаардлагыг хангасан Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн байна. Үүнд:

- а. Зохион байгуулах, манлайлах чадвартай, ажлын идэвх санаачлага сайтай
- б. Холбооны Удирдах зөвлөлд 2-оос доошгүй жил ажилласан байх, ажилласан хугацааны ирц 80%-иас багагүй байх
- в. Ашиг сонирхлын зөрчилгүй, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалахаа илэрхийлсэн байх

3.5.3. Холбооны дэд ерөнхийлөгч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а. Холбооны ерөнхийлөгчийн эзгүйд Удирдах зөвлөлийн хурлыг даргалах
- б. Холбооны ерөнхийлөгчийн эзгүйд Холбоог гадаад, дотоодод ерөнхийлөгчийн шийдвэрийн хүрээнд төлөөлөх
- в. Удирдах зөвлөлийн дэргэдэх Стратеги бодлогын хороог даргалах
- г. Удирдах зөвлөлөөс олгосон бусад эрх
- д. Бүрэн эрхийн хугацаа нь Холбооны ерөнхийлөгчтэй адил байна

3.6. Гүйцэтгэх захирал:

3.6.1. Гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөлийн хурлаас 2 жилийн хугацаагаар томилон ажиллуулж болох бөгөөд улируулан томилж болно.

3.6.2. Гүйцэтгэх захирал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- а. Холбооны ажлын албыг удирдах, Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- б. Өөрийн эрх хэмжээний хүрээнд Холбоог гадаад дотоодод төлөөлөх, гэрээ хэлцэл байгуулах;
- в. Холбооны өмч хөрөнгийг Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах;



- г. Холбооны тайлан мэдээ, санхүүгийн бичиг баримт, бүртгэлийг цаг тухайд нь гаргах, үнэн зөвийг хариуцах;
- д. Улиралд нэг удаа Холбооны үйл ажиллагааны явцын талаар Удирдах Зөвлөлд илтгэн тайлагнах, шаардлагатай бол Зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах;
- е. Холбооны үйл ажиллагааны тайланг хуульд заасны дагуу бэлтгэж, Удирдах Зөвлөлөөр батлуулан, Хууль зүйн яаманд өгөх;
- ж. Дүрэм болон гэрээнд заасан бусад эрх;

3.6.3 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал зэрэг асуудлыг гэрээгээр тусгайлан зохицуулна.

3.6.4 Гүйцэтгэх захирал нь өөрийн бүрэн эрхийн хугацаа дууссан нөхцөлд шинээр гүйцэтгэх захирлыг томилох хүртэл албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

3.6.5 Гүйцэтгэх захирал нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тушаал гаргана.

3.7. Хяналтын зөвлөл:

3.7.1. Хяналтын зөвлөл нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байна. Хяналтын зөвлөл нь Холбооны гишүүдээс 3 жилийн хугацаатай сонгогдоно. Зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүд өөрсдөө сонгоно. 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

3.7.2. Хяналтын Зөвлөлийн гишүүн нь дараах шаардлагыг хангасан этгээд байна;

- а. Холбооны гишүүн ББСБ-г төлөөлөх бүрэн эрх бүхий удирдах дээд албан тушаалтан
- б. Уг албан тушаалтан нь банк, санхүүгийн салбарт 2-с доошгүй жил удирдах албан тушаал хашаж байсан, ямар нэгэн ял шийтгэл хүлээж байгаагүй, хугацаа хэтэрсэн өр зээлгүй байна.
- в. Мэргэжлийн ёс зүйтэй, сонирхлын зөрчилгүй байх
- г. Банк бус санхүүгийн салбарын хууль, эрх зүйн мэдлэгтэй
- д. Төлөөлж буй ББСБ нь сүүлийн 2 жилийн хугацаанд тусгай зөвшөөрлийн хүрээнд ямар нэгэн зөрчилгүй байж, 2-оос доошгүй жилийн хугацаанд холбооны гишүүн байсан

3.7.3. Хяналтын зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- а. Холбооны дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- б. Холбооны өмч хөрөнгийн ашиглалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;
- в. Холбооны Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд зохих хяналт тавих;
- г. Хууль тогтоомжинд заасан бусад эрх;


3.7.4. Хяналтын зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны тайланг бүх гишүүдийн хуралд тайлагнах, ажлын явц, санал дүгнэлтээ Удирдах зөвлөлд оруулж хэлэлцүүлэх эрхтэй.



- 3.7.5. Хяналтын зөвлөлийн гишүүд нь шалгасан бичиг баримт, тайлан баланс, санхүүгийн нууцыг хадгалах үүрэгтэй.
- 3.7.6. Хяналтын зөвлөлийн гишүүд Хяналтын зөвлөлийн журмыг мөрдөн ажиллана.
- 3.7.7. Удирдах зөвлөлийн гишүүн, Удирдах зөвлөлийн дарга буюу Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал нь Хяналтын зөвлөлийн гишүүн байж болохгүй.

ДӨРӨВ. ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрсөн дараахь этгээдүүд холбооны гишүүн байж болно.
- 4.1.1 Санхүүгийн Зохицуулах Хорооноос Банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд;
- 4.1.2 Холбооны ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсөн хуулийн этгээд;
- 4.1.3 Гишүүнчлэлийн гэрээ байгуулж гишүүний татвараа төлсөн хуулийн этгээд.
- 4.2 Холбооны үйл ажиллагааг дэмжигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хүндэт гишүүн байж болох бөгөөд хүндэт гишүүнээр элсүүлэх асуудлыг Удирдах Зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ;
- 4.3 Холбооны гишүүн дараах эрхийг эдэлнэ.
- 4.3.1 Бүх гишүүдийн хуралд оролцох, түүний бүрэн эрхэд хамаарах асуудлаар санал оруулах;
- 4.3.2 Холбооны удирдлагад сонгох, сонгогдох;
- 4.3.3 Холбооны үйл ажиллагаа болон чиг үүрэгт хамаарах асуудлаар мэдээлэл, зөвлөгөө авах, тайлантай танилцах;
- 4.3.4 Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага болон бусад байгууллага, холбоодын өмнө өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр хүндийг Холбоогоор хамгаалуулах;
- 4.3.5 Өөрийн хүсэлтээр холбооны гишүүнчлэлээс гарах;
- 4.3.6 Хуульд заасан бусад эрх;
- 4.4 Холбооны гишүүн дараах үүргийг хүлээнэ.
- 4.4.1 Монгол Улсын хууль тогтоомж, Олон улсын стандарт, энэ дүрмийн заалтыг чанд баримтлан ажиллах;
- 4.4.2 Холбоотой байгуулсан гишүүнчлэлийн гэрээ, гишүүний ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллах;
- 4.4.3 Холбооны зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, Холбооноос зохиож буй арга хэмжээ, хурал семинар, уулзалтанд оролцох;
- 4.4.4 Холбооны гишүүний татвар болон бусад төрлийн санхүүжилт үзүүлэхээр үүрэг хүлээсэн бол цаг тухайд нь биелүүлэх;
- 4.4.5 Холбооны удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаварыг биелүүлэх;
- 4.4.6 Холбооны бусад дүрэм, журмыг дагаж мөрдөх;



ТАВ. ХОЛБООНЫ САН, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ


- 5.1 Холбооны хөрөнгөнд түүний үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө бусад эд хөрөнгө, өмчлөлд буй оюуны зүйлс хамаарна.
- 5.2 Холбооны орлогын эх үүсвэр нь:
- 5.2.1 Гишүүний татвар, хандив;
 - 5.2.2 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив;
 - 5.2.3 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн үйл ажиллагаанаас олсон ашиг орлого;
 - 5.2.4 Гэрээт төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулж олгосон хөрөнгө;
- 5.3 Холбоо нь зохих хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, шимтгэлийг төлнө.
- 5.4 Холбоо нь арилжааны аль нэгэн банкинд төгрөгийн болон валютын харилцах данстай байна.
- 5.5 Холбоо нь улирал, жилийн санхүүгийн тайлан тэнцлийг зохих журмын дагуу гаргаж, хуулийн хугацаанд татварын албанд тушаана.

ЗУРГАА. ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 6.1 Холбоонд дараах үйл ажиллагааг хориглоно:
- 6.1.1 Үйл ажиллагаанаас олсон ашгаас ноогдол ашиг хуваарилах;
 - 6.1.2 Иргэн, хуулийн этгээдэд хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг хариуцах;
 - 6.1.3 Удирдах зөвлөлийн гишүүд, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, ажлын албаны ажилтнууд нь Холбооны нэр ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгийг хувийн ашиг сонирхолд ашиглах, гэрээ хэлцэл байгуулахыг хориглоно.

ДОЛОО. ХОЛБООГ ТАТАН БУУЛГАХ

- 7.1 Холбоог дараах үндэслэлээр татан буулгана:
- 7.1.1 Байгуулагдсан зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаа явуулах шаардлагагүй гэж бүх гишүүдийн 2/3-с доошгүй нь үзэж татан буулгах санал гаргасан;
 - 7.1.2 Албадан татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсон;
 - 7.1.3 Хуульд заасан бусад үндэслэлээр;
- 7.2 Холбоог татан буулгах тохиолдолд уг шийдвэрийг гаргасан байгууллага нь татан буулгах комиссыг томилно.
- 7.3 Татан буулгах комисс нь дараах үйл ажиллагааг явуулна.
- 7.3.1 татан буулгах тухай шийдвэрийг нийтэд мэдээлэх;



- 7.3.2 дуусгалтын баланс, тайлан гаргаж гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;
- 7.3.3 өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулах;
- 7.3.4 Холбооны үлдсэн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм байгууллага байхгүй бол дүрмийн зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулах;
- 7.3.5 Татан буулгах үйл ажиллагаа дууссаныг улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, улсын бүртгэлээс хасуулах.

НАЙМ. БУСАД

- 8.1 Холбоог холбогдох хууль тогтоомжинд заасан үндэслэл, нөхцөл, журмаар өөрчлөн байгуулж /нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ болно.
- 8.2 Холбооны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь хуульд заасан хугацааны дотор улсын бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.
- 8.3 Холбооны удирдлагын оршин байгаа газрыг өөрчлөх тохиолдолд энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад зохих хугацаанд мэдэгдэнэ.
- 8.4 Холбоо нь гишүүний хүлээсэн үүргийн төлөө хариуцлага хүлээхгүй, гишүүн нь Холбооны хүлээсэн үүрэгтэй холбогдсон хариуцлагыг хүлээхгүй.
- 8.5 Холбооны удирдлага болон гишүүдээс энэхүү дүрмийг зөрчин Холбооны үйл ажиллагаа, нэр хүндэд хохирол учруулсан нь нотлогдсон тохиолдолд холбогдох этгээдэд Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан хариуцлага тооцох хүсэлтийг шүүхэд тавина.

